

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ



Улаанбаатар хот

“Нийслэлийн Онцгой байдлын газрын эрхэм зорилго”

Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэл эмзэг байдлыг бууруулах замаар нийслэлийн иргэдийн Монгол Улсын Үндсэн хуулинд заасан амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцвэр алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах.

Нэг. Байгууллага үүсэх болсон түүхэн нөхцөл байдал

Гал түймэртэй тэмцэх байгууллага нь Төр засгийг анх үндэслэн байгуулагчдын нэг жанжин Д.Сүхбаатарын санаачлагаар 1922 оны 01 дүгээр сарын 13-ны Ардын засгийн 35 дугаар хуралдаанаар Гал Түймэртэй Тэмцэх байгууллагыг анх байгуулах шийдвэр гарчээ.

Ардын засгийн газар ийнхүү 1922 оны 01 дүгээр сард шийдвэр гаргаж, Усан хөөргийг түрээсээр ажиллуулж эхэлсний дараахан Галын аюулаас хамгаалах ажлыг сайжруулах зорилгоор “Түймэртэй тэмцэх салаа”-г байгуулахаар шийдвэрлэж, “Түймэр галыг сөнөөх салааны дүрэм”-ийг боловсруулан 2 дугаар сарын 05-нд баталсан байна.

Уг дүрэмд салааны дарга 1, туслах хавсарган бичээч 1, усан хоолойн удирдах хүн 6, их бага усан хөөрөг дарах 17 хүнийг тус тус сангаас цалинжуулах, гал түймэр гарах үед сэргийлэх цэрэг цагдаа нараас арваад хүмүүсийг зарлан авч хүч нэмэгдүүлэх, галын аюултай үед хэрэглэх багаж, урианы их хонх 1, бага усан хөөрөг 3, урт иштэй сүх, хөрөө, дэгээ, ац, малтуур, төмөр хүрз тус бүр арваад эвхмэл төмөр шат 6, их ган хувин бүхий тэрэг 9, бусад зүйл ачих тэрэг 1, усан хөөрөг ба тэрэг чирэх, хөтлөх морьд сангаас бэлтгүүлэх бусад зүйл ачих тэрэг 1, усан хөөрөг ба тэрэг чирэх, хөтлөх морьд 16-г сангаас бэлтгүүлэх бусад морьдыг тухайн байдлыг харгалзан улаа барьж дайчлан хэрэглэх, түймэр галын үед уриа дохио өгөх хүмүүсийг идэвхтэй оролцуулан, олон яам албан газрууд, их ган хувинд ус үргэлжид дүүрэн байлгах, галын үед хулгай дээрмийн явдлаас чанд сэргийлэх гээд гал түймрийг даран сөнөөх үед хойш сууж, саатуулагчдыг цээрлүүлэн шийтгэхийг заасан байна.

Тухайн үед галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэл хүрээний оршин суугчдын үл хөдлөх хөрөнгөнөөс чинээ байдалд нь тохируулан татвар хурааж байжээ. Гэвч энэ дүрмийн заалтыг төсөв зардлаас шалтгаалан хэрэгжүүлж чадалгүй 1922-1925 он хүртэл Нийслэл хүрээнд байсан орос, хятадын худалдааны пүүсийг хувь нийлүүлэн ашиглаж байгаад 1925 онд түүнийг худалдан авч, Түймэр галтай тэмцэх усан хөөргийн газрыг Улаанбаатар хотын захиргааны

мэдэлд байгуулсан нь одоогийн “Алтан гадас” одонт Аврах, гал унтраах 10 дугаар анги болон өргөжжээ.

Улаанбаатарт гарсан анхны томоохон гал түймэр нь 1926 онд гарч Гандан хүрээнд олон арван лам нарын сууц, гэр байшин, хашаа эд хогшил, хөрөнгө шатсан бөгөөд 1930 онд Оросын худалдааны нийгэмлэг, хорооны ерөнхий хороо зэрэгт гарсан галуудыг нэрлэж болно.

1934 онд Дотоодын Хамгаалах Газрын дэргэд Галын аюулаас хамгаалах комиссыг зохион байгуулсан бөгөөд Сэлэнгэ, Дорнод, Ховд, Хөвсгөл, Архангай зэрэг 5 аймагт тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй харъяа комисс байгуулжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1935 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолоор Галын аюулаас хамгаалах комиссыг татаж буулгаж, Гал түймрээс сэргийлэх хэлтсийг байгуулж, Дотоодыг хамгаалах газрын бүрэлдэхүүнд ажиллуулсан байна.

Мөн тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны удирдлагад ажиллаж байсан Гал команд /усан хөөрөг/-ыг Гал түймрээс сэргийлэх хэлтсийн мэдэлд шилжүүлэн цэрэгжүүлжээ. Үүний зэрэгцээ төв хөдөөгийн зарим байгууллагад гэрээт Гал команд, постууд байгуулагдсанаар тус улсын доторхи гал түймрээс сэргийлэн хамгаалах ажил, Гал түймрийг сэргийлэх хэлтсийн харъяанд шилжүүлэн Гал сэргийлэн хамгаалах хэлтсийг байгуулсан байна.

1960 оноос Нийслэл хотод үйлдвэр, тээвэр барилгын бие даасан салбарууд өсөн хөгжиж эхэлсэнтэй холбогдуулан 1954 онд аж үйдвэрийн комбинатын, Батлан хамгаалах нийгэмлэгийн Гал команд, 1958 онд Нефть хамгамжийн баазын, 1959 онд Цахилгаан станц, Төв бараа бааз, Үйлдвэр комбинат, 1960 онд Нисэх онгоцны төв буудалд, Дулаанхааны Мод боловсруулах бааз, Хатгалын ноосны үйлдвэр, Дорнодын хамжлага бааз, Баян-өлгий аймгийн төв, 1961 онд Улсын их дэлгүүрт галын пост, 1962 онд Дархан хотод Гал команд, 1981 онд Баянгол дах Олон улсын пионерийн зусланд, 1982 онд Багануур дүүрэгт, 1984 онд Мод боловсруулах комбинатад, мөн онд Шувуун фабрикт, 1990 онд Багахангай дүүргийн Өндөр толгойд, Мааньтад 1991 онд Нийслэл хотын Сүхбаатар дүүрэгт /Гал унтраах 34 дүгээр анги/ тус тус ажиллах болсон юм.

МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын СнЗ-ийн 1971 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 328/432 дугаар тогтоолоор Гал сэргийлэн хамгаалах хэлтсийг Хяналтын хэлтэс, Унтраах албаны хэлтэс, Туршин шалгах станц, Засан сэлбэх засварын тасаг бүхий Галын аюулаас хамгаалах газар болгон өртгөсөн байна.

1991 онд Засгийн газрын 90 дугаар тогтоол гарч аймаг нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадыг шинээр зохион байгуулан Цагдаагийн байгууллагын бүрэлдхүүнээс гарган, аймаг, нийслэлийн Засгийн даргын Тамгын газарт харъяалуулж, Галын Аюулаас Хамгаалах Газрыг Гал түймэртэй тэмцэх газар болгон өргөтгөн зохион байгуулсан байна.

Улсын Их Хурал 1999 онд “Галын аюулгүй байдлын тухай” Монгол Улсын хууль баталснаар Гал түймэртэй тэмцэх газар, Цагдаагийн Ерөнхий Газрын бүтэц бүрэлдэхүүнээс гарч Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг болон зохион байгуулагдсан бөгөөд Захиргааны Удирдлагын, Шинжилгээ судалгааны, Гал унтраах хэлтэстэйгээр ажиллаж байлаа.

Гал түймэртэй тэмцэх газрын бүтэц орон тоо:

Засгийн газрын 1999 оны 209 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх газрын дүрмийг баталсан бөгөөд одоо улсын хэмжээнд Гал түмэртэй тэмцэх байгууллагад төв орон нутгийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс 18, алба 4, гал унтраах анги 42, галын хэсэгт 24 тэдгээрт 2800 гаруй офицер, улирсан албан хаагч ажиллаж байсан.

Гал түмэртэй тэмцэх газрын бүтэц:

-Захиргааны удирдлагын хэлтэс

-Гал унтраах хэлтэс

-Шинжилгээ, судалгааны хэлтэс

-“Гал импекс” Улсын үйлдвэрийн газар гэсэн газар, хэлтэстэй ажиллаж байсан байна.

Тус газарт Монгол улсад алдар нэрээ цурайтуулсан Монгол Улсын баатар Л.Дандар, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, төрийн соёрхолт, Ардын жүжигчин Г.Гомбосүрэн, Ардын жүжигчин Данзан, Төрийн соёрхолт, зохиолч эрдэмтэн С.Удвал, Гавъяат жүжигчин Л.Нямсүрэн, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн М.Таяа, Х.Төмөрбаатар, Р.Авгаандорж, Ц.Дорж, Ч.Самдан, Ч.Махцэрэн, Д.Маам, нарын олон арван дайчид ажиллаж байсны зэрэгцээ, анхны “Шударга журам” медальтан Ж.Равдан зэрэг соёл, ажил үйлс, Эрэлхэг зоригоороо шалгарсан бахархан дуурайх ахмадууд ажиллаж байсны гадна амиа алдсан гал сөнөөгч агсан Д.Баатар, Ж.Баярсайхан, шүхэрчин, гал сөнөөгч С.Чүлтэмсүрэн, С.Батбаатар, салааны захирагч асан М.Батхаан зэрэг албан хаагчдаараа бахархаж явдаг юм.

Гал түймэртэй тэмцэх газрын үндсэн чиг үүрэг:

Гал түймэртэй тэмцэх байгууллагын үйл ажилгааны эрхэм зорилго нь: гал түмэртэй тэмцэх үүргээ хэрэгжүүлэн Үндсэн хуулиар тогтоосон хүмүүнлэг ардчилсан нийгэмд бүх иргэн амьд явах, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, төр, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулан улс орны эдийн засгийн хөгжлийг тогтворжуулахад оршино.

Гал түмэртэй тэмцэх газрын үндсэн чиг үүрэг нь: хот суурин болон ой, хээрийг гал түймэрийн хэрэг, зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, эзэн шалтгааныг тогтоох явдал юм.

Засгийн газрын 2004 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2002 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “Гамшгаас хамгаалах ерөнхий газар” гэж нэмж, мөн хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх ажлын хүрээнд “Засгийн хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “Гал түймэртэй тэмцэх газар”, “Улсын нөөцийн газар” гэснийг Батлан хамгаалахын сайдын эрхлэх ажлын хүрээнд, “Засгийн газрын тохижуулагч агентлаг” гэсэн хэсгийн “Иргэний хамгаалтын газар” гэснийг тус тус хассанаар Гал түймэртэй тэмцэх газар нь Улсын нөөцийн газар Иргэний хамгаалалтын газартай нэгдэж, Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулагдаж, энэ бүтцэд нэгдсэн юм.

Ерөнхий сайдын 2004 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 08 дугаар захирамжаар тус газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан юм. Мөн Ерөнхий сайдын 2004 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 17 дугаар захирамжаар тус газрын дүрмийг баталж өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор нийслэлийн Иргэний хамгаалтын штаб, Гал түймэртэй тэмцэх хэлтсийг нэгтгэж, нийслэлийн Гамшгаах хамгаалах штаб болгожээ.

Нийслэлийн Гамшгаах хамгаалах штаб нь Монгол улсын Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор “Газар”-ын статустай болж, нэр нь өөрчлөгдөж, нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргүүдэд Онцгой байдлын хэлтэстэй болж өргөжсөн ба дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан .

Үүнд:

1. Тамгын хэлтэс
2. Мэргэжлийн удирдлагын хэлтэс
3. Гал түймэртэй тэмцэх хэлтэс
4. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс
5. Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс
6. Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс
7. Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс
8. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс
9. Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
10. Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс
11. Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс
12. Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс

2008 онд нийслэлийн Онцгой байдлын газар нь Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2008 оны 02 дугаар сарын 12-ны 74 дүгээр тушаалаар бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Үүнд:

1. Гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтэс
2. Гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтэс
3. Тамгын хэлтэс
4. Нөөцийн алба
5. Төрийн ордны галын хэсэг
6. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс
7. Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс
8. Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс
9. Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс
10. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс
11. Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
12. Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс
13. Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс
14. Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
15. 13 гал унтраах анги /10,11,14,18,26,28,29,30,34,63,64,65,80/
16. Шуурхай бүлэг 105
17. Аврах отряд

Мөн 2010 онд нийслэлийн Онцгой байдлын газар нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2010 оны 10 дугаар сарын 19-ний 445 дугаар тушаалаар бүтэц зохион байгуулалт, орон тоог шинэчлэн батлаж офицер 174, ахлагч 621 нийт 795 албан хаагчидтай байхаас өнөөдрийн байдлаар офицер 162 буюу 93,1%, ахлагч 582 буюу 93,7 %, нийт 744 албан хаагчтай орон тооны нөхөн хангалт 93,5 %-тай, 2012 ондоо ажиллаж байна

Үүнд:

1. Тамгын хэлтэс
2. Гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтэс
3. Гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтэс
4. Нөөцийн алба
5. Шуурхай бүлэг-105
6. Аврах салбар
7. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс
8. Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс
9. Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс
10. Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс
11. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс
12. Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
13. Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс
14. Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс
15. Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
16. 13 Гал унтраах анги /10,11,14,18,26,28,29,30,34,63,64,65,80/

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор нийслэлийн Иргэний хамгаалалтын штаб, Гал түймэртэй тэмцэх хэлтсийг нэгтгэн нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб байгуулагдаж, 2005 оны 48 дугаар тогтоолоор нийслэлийн Онцгой байдлын газар болж өөрчлөгдөн, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах, гамшгаас хамгаалах арга хэмжээнд албад, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, ард иргэдийг сургах үндсэн үүргийг хэрэгжүүлж байна.


- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоог идэвхижүүлж, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх;

- Төрийн албаны сахилга хариуцлага, ёс зүйг дээдлэх;

- Албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллаж амьдрах нөхцлийг дээшлүүлэх зорилго дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.



Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтэц бүрэлдэхүүнийг хүснэгтээр үзүүлбэл:



Хоёр. Баримтын түүх

Нийслэлийн Онцгой байдлын газрын баримтын түүхийг авч үзвэл тус хэлтэс нь /хуучин нэрээр/ Гал түймэртэй тэмцэх газартай нэг архивтай, хариуцдаг нэг ажилтантай байсныг 1999 онд архивын эрхлэгчээр Ц.Төгсцэцэгийг томилсноор архивын баримтаа салган тусдаа фонд үүсгэн склад, сейфенд байсан эмх замбараагүй, задгай баримтуудыг цуглуулан авч, он цаг, агуулга сэдэв, төрөл зүйлээр ангилан цэгцэлж, баримт бичгээ бүрдүүлж эхэлсэн байна.

Улмаар нийслэлийн архивын газартай ажил төрлийн холбоо тогтоон ажиллаж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө авч, 2004 онд байнга хадгалах баримт бичгийн бүртгэл үйлдэж, нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт Бичиг Нягтлан Шалгах Арга Зүйн Комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 1995-2003 оны 7 жилийн 160 хадгаламжийн нэгжийг шилжүүлж, 129 дүгээр хөмрөгийг үүсгэсэн байна.

Үүнд: хэлтсийн даргын тушаал, зөвлөлийн хурлын тэмдэглэл, галын хэргийн нотломж, галын зөрчлийн тэмдэглэл, гал унтраасан нотломж, жилийн ажлын төлөвлөгөө, тайлан зэрэг төрлийн баримт бичгээр бүрдсэн байна.

Хэдийгээр 1995-2003 оны байнга хадгалах баримтыг нийслэлийн Архивын газарт шилжүүлсэн сайн талтай ч 1986-1994 оны баримтаар бүртгэл данс үйлдээгүй орхисон нь одоо тус газрын архивт хадгалагдаж байна. Энэ хугацааны баримтад ихэвчлэн хэлтсийн даргын тушаал, даргын зөвлөлийн хурлын протокол, голчлон галын акт зэрэг баримт бичиг байгаа юм.

Үүнээс өмнө 1990-1994 оны байнга хадгалах баримтыг Нийгмийг аюулаас хамгаалах яам болон Цагдаагийн ерөнхий газрын архивт шилжүүлсэн гэх боловч албан ёсоор хүлээлцсэн акт байхгүй байна.

Засгийн газрын 2004 оны 01 дүгээр тогтоолоор Улсын Иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газрыг нэгтгэж, Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулснаар Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб, Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газар нь Онцгой байдлын ерөнхий газар болон статусын хувьд өөрчлөгдсөнөөр нийслэлийн

Онцгой байдлын газар нэртэйгээр үйл ажиллагааны цар хүрээ өргөжин, баримт бичгийн хэмжээ, нэр төрөл эрс ихэссэн байна.

2004 оноос хойш байгууллагын баримт бичгийн бүрдэл нь үйл ажиллагааны явцад үүссэн удирдлагын тушаал, шийдвэр, хурал, зөвлөлгөөний тэмдэглэл, нийслэлийн Засаг даргаас өгсөн үүргийн биелэлт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, үр дүнгийн гэрээ, удирдамжийн шалгалтын илтгэх хуудас, шуурхай зөвлөлгөөний тэмдэглэл, ажлын байрны тодорхойлолт, ойн баярын холбоотой баримт бичиг, сургалт, сурталчилгаатай холбоотой баримт бичиг, ирсэн, явуулсан бичиг нөхцөл байдлын мэдээ, хоногийн мэдээ, гал түймэр гарсан болон унтраасан тухай нотломж, галын зөрчил барагдуулсан тэмдэглэл, дуудлага хүлээн авсан бүртгэл, аврах багаж хэрэгслийн хүчин чадлын тэмдээ, тайлан, хүн малын гоц халдварт өвчний үед ажилласан тайлан, мэдээ, судалгаа, санхүүгийн холбогдолтой баримт бичиг, эд хөрөнгийн дахин үнэлгээ, үндсэн хөрөнгийн тооллогын баримт, тендерийн материал зэрэг 69 нэр төрлийн баримт бичгээр сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт хийж иржээ.

Тус газрын архивын үйл ажиллагааг Үндэсний Архивын Газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу нөхөн бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх, сэлбэн засах, байгууллага дээр хадгалах хугацаа дууссан баримтыг нийслэлийн Архивын газарт шилжүүлэх, устгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд С.Оюунгэрэл, Н.Болормаа нарыг томилон ажиллуулж, нийслэлийн Архивын газрын мэргэжилтэн Д.Анхбаяраас заавар зөвлөгөө авч, дараах ажлуудыг хийж гүйцэтгэж, нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-оор хэлэлцүүлэхэд бэлэн болгосон..

1. Тус газрын архивын сан хөмрөгт байгаа баримтуудыг байнга, түр, 70 жил, устгах төрлөөр ялгаж, өмнө бүрдүүлсэн баримт бичиг хадгалах хугацаагаар холилдож үдэгдсэн 84 хадгаламжийн нэгжийг задалж, хуудасны тоо хэтэрч, 700-800 хүртэл хуудастай хадгаламжийн нэгжийг задалж 150 хадгаламжийн нэгж болгон, нүүр бичилт буруу бичигдсэн 47 хадгаламжийн нэгжийг шинээр хавтаслан, хавтас нь урагдаж элэгдсэн 33 хадгаламжийн нэгжид сэлбэн засалт хийж, хуудсыг дугаарлаж, байнга хадгалах хадгаламжийн нэгжид товъёог үйлдэж, баталгааны хуудас бичсэн.

Мөн санхүүгийн баримтнаас ажилтнуудын цалингийн цэсийг салган авч, 2009-2011 оны нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тушаалыг үндсэн үйл ажиллагааны болон боловсон хүчний чиглэлээр ангилан боловсон хүчний чиглэлээр боловсруулсан тушаал /Б тушаал/-ыг түр хадгалах баримтнаас авч, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд хамруулан данс бүртгэлийг үйлдэж:

1986-2011 оны байнга хадгалах 336 хадгаламжийн нэгж,

1996-2011 оны түр хадгалах 538 хадгаламжийн нэгж,

1987-2011 оны 59 хадгаламжийн нэгжээр 70 жил,

Хадгалах хугацаа дууссан 152 хадгаламжийн нэгжээр устгах хэргийн актыг тус тус үйлдэн байгууллагын Баримт Бичиг Нягтлан Шалгах Комиссын хурлаар хэлэлцүүлсэн.

2. Архивын сан хөмрөгийн бүрдлийг хангах үүднээс 1986-1994, 2002 оны ажлын төлөвлөгөө тайлан, мөн 2009 оноос өмнөх оны санхүүгийн баримтын бүрдэл хангалтгүй байсныг байгууллагын ББНШК-ын гишүүдтэй хамтарч ажил хариуцсан хүмүүсээс асууж, ширээ шүүгээнээс эрэлт хайлт хийсэн боловч олдоогүй.

Харин 2010-2011 оны удирдамжийн шалгалт хийсэн ажлын илтгэх хуудас, даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, 2011 оны галын нотломж, санхүүгийн харилцахын баримт, шалгарсан тендерийн баримт бичгийг хариуцсан мэргэжилтнүүдээс хүлээн авч, архивын сан хөмрөгийн бүрдүүлэлтэнд баяжилт хийсэн.

3.Тус газрын үндсэн үйл ажиллагааны нэг хэсэг аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын дуудлага, ялангуяа галын аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, таслан зогсоох, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, гал гарсан зөрчлийг тогтоох, хохирлыг нөхөн төлүүлэх, ард иргэдэд заавар зөвлөмж өгөх, зэрэг багц ажлын үр дүнд үүссэн гал түймэр гарсан, унтраасан тухай нотломж, гал гарсан тухай зөрчлийн тэмдэглэл, шинжээчийн дүгнэлт, магадлагаа зэрэг баримт бичгүүд нь байгууллагын ажлын онцлогоос шалтгаалан судалгаа шинжилгээ хийх, Олон Улсын мэдээ тайланд оруулах, харьцуулалт гаргах, галын аюулаас урьдчилан сэргийлэх цаашдын зорилгоо тодорхойлох, мөн энэ төрлийн баримтаас ард иргэд архиваас лавлагаа

үйлчилгээ авах эрэлт хэрэгцээ их байдаг учир байгууллагын Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн “байнга” хадгалах баримт бичигт оруулахаар шийдвэрлэн байнга хадгалах баримт бичгийн бүртгэлд бүртгэж орууллаа.

Жич: Галын нотломж нь Гал гарсан тухай нотломж, Гал унтраасан тухай нотломж, Галын зөрчлийн тэмдэглэл, Галын зөрчил барагдуулсан тэмдэглэл, Галын шинжээчийн дүгнэлт, магадлагаа гэсэн нэртэй баримт бичгүүдээс бүрдэж ирсэн бөгөөд гал гарсан хэрэг нь сар дамжин шалгагдаж, бүрддэг тул нэг хадгаламжийн нэгжид саруудыг бүтнээр оруулахад хэргийн утга тасарч, хуудасны тоо 250-аас илүү гардаг учраас хадгаламжийн нэгжүүдэд сарын баримт тасарч үдэгдсэн болно.

2011 оноос дээрх төрлийн баримт нь тус тусдаа биш нэгдэж, нэг хавтаст хэрэг болж бүрдэлтэнд орох юм.

4. Нийслэлийн Онцгой байдлын газрын архивт хадгалагдаж байсан Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах депо, орон сууцны барилгын зураг 2 хавтас, Дархан-уул аймгийн Онцгой байдлын газрын даргын тушаал 3 хадгаламжийн нэгж, Гал түймэртэй тэмцэх газрын даргын тушаал 1 хадгаламжийн нэгж /Үндэсний төв архивт дутуу шилжүүлэгдсэн/-ийг Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр тус тус шилжүүлсэн.

5. Цэргийн тэтгэвэрт гарсан, ажлаас халагдсан хүмүүсийн 560 хувийн хэргийг үсгийн дарааллааар ялган бүртгэл үйлдэж өгсөн.

5. Мөн нийслэлийн Онцгой байдлын газрын “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу байгууллагын дэргэдэх БНШК-ын бүрэлдэхүүнийг даргын тушаалаар шинэчлэн томилж, комиссын гишүүдийн ажиллах журмын талаар заавар зөвлөгөө өгч, ажилтнуудаас санал авсны үндсэн дээр байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, байгууллагын зохион байгуулалтын нэгжид индекс олгож, даргын тушаалаар баталгаажуулан мөрдүүлэн ажиллаж байна.

Гурав. Хөмрөгийн баримтын тодорхойлолт

Одоо нийслэлийн Онцгой байдлын газрын архивын сан хөмрөгт 1986-2011 оны байнга хадгалах 329 хадгаламжийн нэгж, 1996-2011 оны түр хадгалах

540 хадгаламжийн нэгж, 1987-2011 оны 70 жил хадгалах 59 хадгаламжийн нэгж, 1996-2010 оны устгах 152 хадгаламжийн нэгжийн бүрэлдэхүүнтэй баримтаар данс бүртгэл үйлдэн, албаны үйл ажиллагаанд болон иргэд, хөдөлмөрчдөд лавлагаа, үйлчилгээ үзүүлж байна.

Баримт бичгийн төрлөөр авч үзвэл 2004 оноос хойш байгууллагын баримт бичгийн бүрдэл нь үйл ажиллагааны явцад үүссэн удирдлагын тушаал, шийдвэр, хурал, зөвлөлгөөний тэмдэглэл, нийслэлийн Засаг даргаас өгсөн үүргийн биелэлт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, үр дүнгийн гэрээ, удирдамжийн шалгалтын илтгэх хуудас, шуурхай зөвлөлгөөний тэмдэглэл, ажлын байрны тодорхойлолт, ойн баярын холбоотой баримт бичиг, сургалт, сурталчилгаатай холбоотой баримт бичиг, ирсэн, явуулсан бичиг нөхцөл байдлын мэдээ, хоногийн мэдээ, гал түймэр гарсан болон унтраасан тухай нотломж, галын зөрчил барагдуулсан тэмдэглэл, дуудлага хүлээн авсан бүртгэл, аврах багаж хэрэгслийн хүчин чадлын тэмдээ, тайлан, хүн малын гоц халдварт өвчний үед ажилласан тайлан, мэдээ, судалгаа, санхүүгийн холбогдолтой баримт бичиг, эд хөрөнгийн дахин үнэлгээ, үндсэн хөрөнгийн тооллогын баримт, тендерийн материал зэрэг 69 нэр төрлийн баримт бичгээр сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт хийж иржээ.